



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01

Шарга

Шагналд дэмжих тухай

Монгол улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Тус сумын Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, мөн ажиллаж байх хугацаандаа гаргасан ажлын амжилтыг нь үнэлэн Тувааннайдангийн Гэрэлтуяа, Хоролын Баасанжав, Далхаан Батсүх нарыг "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар шагнуулах тухай тодорхойлолтыг тус тус дэмжин аймгийн Засаг дарга /А.Эрдэнэбаатар/-т уламжилсугай.

2. Материалыг бүрдүүлж холбогдох газарт хүргүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.АЗБАЯР

00048



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 02

Шагга

Хөрөнгө зарах тухай

Монгол улсын Засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, Түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Монгол улсад Шинэ үндсэн хууль батлагдсаны 22 жилийн ойн баярт зориулсан хууль сурталчилах өдөрлөгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Хууль сурталчилах өдөрлөгт 600000 төгрөг зарцуулахыг төсвийн ерөнхий менежер /Л.Сэрсмаа/, ня-бо /М.Бямбадорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ЧАЗБАЯР

"ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ" БАТЛАГДСАНЫ
22 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН УДИРДАМЖ

Зорилго: Шинэ үндсэн хуулийн ач холбогдлыг таниулах, хуулийг дээдлэн сахих иргэн болон төлөвшүүлэх оршино.

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Төсөв/мян.төг/	Хариуцах эзэн
1	"Шинэ үндсэн хууль"-ийн баярт зориулсан үндэсний бөхийн барилдаан	2014.01.10 14 ⁰⁰ цаг	150,0	ИТХ-ын Тэргүүлэгчид, Бөхийн холбоо
2	Шагайн харваа	2014.01.10 14 ⁰⁰ цаг	150,0	ИТХ-ын Тэргүүлэгчид, Шагайн холбоо
3	Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээ	2014.01.13- ны 15 ⁰⁰ цаг	41,0	ИТХ-ын дарга, ИБ-ийн ажилтан, Сургуулийн НА, ТНУ-ны багш нар
4	8-11-р ангийн сурагчдын дунд Илтгэлийн уралдаан	2014.01.08	53,0	ХУЗАН-ын ахлагч, МХ-УЗ-ын багш нар
5	10-11-р ангийн сурагчдын дунд "Эссэ" бичлэгийн уралдаан	2014.01.06- 01.10	53,0	ХУЗАН-ын ахлагч, МХ-УЗ-ын багш нар
6	8-9-р ангийн сурагчдын дунд зохион бичлэгийн уралдаан	2014.01.06- 01.10	53,0	ХУЗАН-ын ахлагч, МХ-УЗ-ын багш нар
7	Оюутан залуучуудын "Баскет-шоу" сагсан бөмбөгийн тэмцээн	2014.01.11- 01.12	60,0	Сагсан бөмбөгийн холбоо, НАМЗХолбоо
8	"АХА" цэнгээнт хөтөлбөр	2014.01.12	40,0	ИТХ-ын Тэргүүлэгчид
	Нийт		600,0	